



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 17 (350)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай*
- *Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2004 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны тавдугаар сарын 4 №17 (350)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	336
203.	Гаалийн тарифын тухай хуульд нэмэлт оруулах тухай	336
204.	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай	336
205.	Хэлэлцээр соёрхон батлах тухай	336
206.	Хэлэлцээр соёрхон батлах тухай	337
207.	Хэлэлцээр соёрхон батлах тухай	337

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

208.	Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 14	337
209.	Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 15	338
210.	Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 16	338
211.	"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс байгуулах тухай	Дугаар 17	339

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

212.	Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилж тухай	Дугаар 55	340
213.	Шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай	Дугаар 56	340
214.	Уул овооны тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолыг үйлдэх тухай	Дугаар 57	340

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

215.	Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах тухай	Дугаар 67	342
216.	Хорин цэрийн дэглэм, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг бууруулах тухай	Дугаар 69	346
217.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 70	346

Тав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

218.	Иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйлийн 4 дэх заалтууд үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 2/01	347
------	--	-------------	-----



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 16 дахь заалт нэмсүгэй.

хэрэгсэл, тоноглол. Энэ заалтад хамаарах барааны жагсаалтыг Засгийн газар батална."

"9.2.16. хийн түлш, хийн түлшний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ГААЛИЙН ТАРИФЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тарифын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 14 дэх заалт нэмсүгэй.

хэрэгсэл, тоноглол. Энэ заалтад хамаарах барааны жагсаалтыг Засгийн газар батална."

"14/хийн түлш, хийн түлшний сав, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын машин, техник,

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 19 дэх хэсэг нэмсүгэй.

орлогын албан татварыг эхний 5 жилд бүрэн чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө."

"19. Хийн түлшний салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын зөвхөн энэ үйл ажиллагаанаас олсон

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2003 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Итали Улсын Засгийн газар хоорондын Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх яадлаас урьдчилан сэргийлэх тухай Хэлэлцээрийг Монгол

Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2003 оны 11- дүгээр сарын 19-ний өдөр Пхеньян хотноо гарын үсэг зурсан Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн

мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2003 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Вена хотноо гарын үсэг зурсан Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн

мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Төрийн албаны тухай хуулийн 28.5, 28.10-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар баталж, 2004 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан

Төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

“Төрийн өндөр албан тушаалын болон түүнтэй адилтгах төрийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 74 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 14 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТАН БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ТӨРИЙН АЛБАН ТУШААЛТНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа	Түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл	Албан тушаалын цалингийн хэмжээ (сард төгрөгөөр)
ТӨ-I		254200
ТӨ-II		191600
ТӨ-III		147500
ТӨ-IV	ТӨ-IVА	141500
ТӨ-V	ТӨ-VA	131100
ТӨ-VI	ТӨ-VI А	125000



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Улсын Их Хурлын гишүүний туслахын албан тушаалын сарын цалингийн хэмжээг 82000 төгрөгөөр, бие төлөөлөгч-туслахын албан тушаалын сарын цалингийн хэмжээг 53700 төгрөгөөр тус тус баталж, 2004 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан

"Зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 75 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. "Монгол Улсын шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ"-г 1 дүгээр хавсралтаар, "Монгол Улсын прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын цалингийн хэмжээ"-г 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталж, 2004 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын 2002 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 77 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын 2004 оны 16 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Албан тушаал	Албан тушаалын цалингийн хэмжээ (сард төгрөгөөр)
1	Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч	126100
2	Нийслэлийн шүүхийн шүүгч	115900
3	Аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч	121000
4	Аймгийн шүүхийн шүүгч	112200
5	Дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	113600
6	Дүүргийн шүүхийн шүүгч	108400
7	Сум, сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч	113600
8	Сум, сум дундын шүүхийн шүүгч	108400

Монгол Улсын Их Хурлын 2004 оны
16 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН
ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛЫН
ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

№	Албан тушаал	Албан тушаалын цалингийн хэмжээ /сард төгрөгөөр/
1	Улсын ерөнхий прокурорын газрын туслах прокурор	124600
2	Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор	114600
3	Нийслэлийн прокурор	124000
4	Нийслэлийн прокурорын орлогч	115300
5	Нийслэлийн прокурорын газрын туслах прокурор	106900
6	Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор	105000
7	Аймаг, тээврийн прокурор	119000
8	Аймаг, тээврийн прокурорын орлогч	110400
9	Аймаг, тээврийн прокурорын газрын туслах прокурор	106900
10	Аймаг, тээврийн прокурорын газрын хяналтын прокурор	105000
11	Дүүргийн прокурор	109000
12	Дүүргийн прокурорын орлогч	106900
13	Дүүргийн прокурорын газрын туслах прокурор	105000
14	Дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор	104000
15	Сум, сум дундын ахлах прокурор	109000
16	Сум, сум дундын прокурорын газрын хяналтын прокурор	104000

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 4 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

**"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт
бүс байгуулах тухай**

Чөлөөт бүсийн тухай хуулийн 5.1-д заасныг
үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2. "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн
газрын хэмжээг 900 га-аар тогтоож, хилийн заагийг
хавсралтаар баталсугай.

1. Дорноговь аймгийн нутагт Замын-Үүд
боомтыг түшиглэн худалдаа, үйлдвэрлэл, аялал,
жуулчлалын үйл ажиллагаа явуулах "Замын-Үүд"
эдийн засгийн чөлөөт бүс байгуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С. ТӨМӨР-ОЧИР**

Монгол Улсын Их Хурлын 2004 оны
17 дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

"Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүсийн хилийн
зааг

**"ЗАМЫН-ҮҮД" ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН ГАЗРЫН
ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОБИЦОЛ**

№	Цэгийн дугаар	Өргөрөг			Уртраг		
		Град ^o	Мин ^o	Сек ^o	Град ^o	Мин ^o	Сек ^o
1	А	43	42	25.5	111	54	53.7
2	Б	43	41	51.7	111	55	41.5
3	В	43	41	32.0	111	54	41.0
4	Г	43	41	17.0	111	52	48.0
5	Д	43	41	59.9	111	51	51.3
6	Е	43	43	00.0	111	51	55.0
7	Е	43	42	24.4	111	53	36.0
8	Ж	43	41	37.7	111	56	13.9
9	З	43	41	36.5	111	56	13.2
10	И	43	41	48.8	111	55	30.2

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 4 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Сүхбаатарын Ганчимэгийг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Нэргүйн Батчимэгийг Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

Бадарчийн Түмэнбаярыг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Дагвадоржийн Буянжаргалыг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн,

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 4 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 56

Улаанбаатар хот

Шүүгчийг сэлгэн ажиллуулах тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 42 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

дугаар шүүхийн шүүгчийн албан тушаалд сэлгэн ажиллуулсугай.

Буниагийн Оюунцэцэгийг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас Өвөрхангай аймаг дахь сум дундын 2

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2004 оны 4 дүгээр
сарын 23-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

Уул овооны тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолыг үйлдэх тухай

Монголын ард түмэн уул овооны төрийн тайлга тахилгын ёслолын өнө эртний түүх уламжлалтай билээ. Эрт цагаас Монголчууд уул овоог орон нутгийн хэмжээнд шүтэж тахиж байснаас гадна түүхийн сурвалжид тэмдэглэснээр XIII зууны үед Чингис хаан Бурхан Халдун уулыг урийн урд тахиж, үе тутам шүтэж байхыг зарлиг буулгаж байв. Үүнээс хойш Богд хан, Отгонтэнгэр, Бурхан Халдун уулыг тус тус төрийн ёслолын хэмжээнд зарлигаар тахиж байсны дээр Богд хааны зарлигаар Дарьгангын Дарь овоог тахисан байна.

Эх болсон байгаль дэлхийгээ хүмүүнчлэн үзэж хайрлан хамгаалах, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг бататган бэхжүүлэх, ард иргэдийнхээ эх оронч, үндэсний үзлийг сэргээн бадрах утга санаа, үйлдлэг сэтгэлгээг агуулдаг энэхүү тайлга тахилгын ёслолын ач холбогдол гүнээ оршиж байдаг билээ.

Өвөг дээдсийнхээ өнө эртний энэ сайхан зан заншил, түүх соёл, төрт ёсны уламжлалыг баримтлан уул овооны тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолыг эдүгээ цагийн байдалд нийцүүлэн үйлдэж байх нь зүйтэй хэмээн үзэж Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ нь:

овоог тахих төрийн тахилгын ёслолыг үйлдэх нь зүйтэй хэмээн үзэж дээрхи уул, овоог Төрийн тахилгатай уул, овоо хэмээн нэрлэсүгэй.

2. Төрийн тахилгатай овоо, уул бүрийн тэнгэрийг тайх тахилгын ёслолыг 4 жилд нэг удаа үйлдсүгэй.

3. Төрийн тахилгатай овоо, уулын тэнгэрийг тайх тахилгын ёслолд төрөөс албан ёсоор оролцох оролцоог уг зарлигийн хавсралт журмаар баталсугай.

4. Тахилгын ёслолын дэг, жаяг төрийн бус болон шашны байгууллага, ард иргэдийн оролцоог уул, овоо тус бүрийн онцлогийг харгалзан үзэж журамлан, тахилга үйлдэх саналаа тахилгын ёслол болохоос 3 сараас доошгүй хугацааны өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт ирүүлж байхыг холбогдох аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

5. Энэхүү зарлиг бууж байгаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 110 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

1. Бурхан Халдун уул, Богд хан хайрхан уул, Отгонтэнгэр уулын тэнгэрийг тайх, Дарьгангын Дарь

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2004 оны 04 дугаар сарын 23-ны өдрийн
57 тоот зарлигийн хавсралт

ТӨРИЙН ТАХИЛГАТАЙ УУЛ ОВООНЫ ТЭНГЭРИЙГ ТАЙХ
ТАХИЛГЫН ЁСЛОЛЫН ЖУРАМ
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1. Төрийн тахилгатай уул овооны тэнгэрийг тайх
ёслолын журмын зорилго

1.1. Энэхүү журмаар Богдхан хайрхан уул,

Бурхан Халдун уул, Отгонтэнгэр уулын тэнгэрийг тайх, Дарьгангын Дарь овоог тахиж төрийн тайлга тахилгын /цаашид "ёслол" гэх / ёслолд төрийн оролцоо, ёслолыг үйлдэх газар, санхүүжилт болон бусад зүйлсийг журамлан тогтооно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

2. Ёслолд албан ёсоор оролцох бүрэлдэхүүн

2.1 Уг ёслолын ажиллагаанд төрөөс албан ёсоор дараахи бүрэлдэхүүнтэйгээр оролцоно:

-Монгол улсын төрийг төлөөлж элч төлөөлөгчийг /цаашид " төрийн элч төлөөлөгч" / гэх Монгол Улсын Ерөнхийлөгч томилох бөгөөд төрийн элч төлөөлөгч нь сайдаас доошгүй албан тушаалтан байх буюу төрийн өндөр албанд ажиллаж байсан зүтгэлтэн байж болно.

-Ёслолд төрийн элч төлөөлөгчийг тухайн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга болон бусад бараа бологсад дагалдана.

- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын аль нэг нь өөрийн

тааллаар оролцох бол тухай ёслолд Монгол улсын төрийг төлөөлнө.

- Төрийн элч төлөөлөгч нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн айлтгал бичиг, торго, хүж, сум болон төрөөс илгээдэг бусад эд зүйлсийг ёслолын ажиллагаанд төрийн нэрийн өмнөөс өргөн барих үүрэг гүйцэтгэнэ.

2.2 Ёслолын ажиллагааг тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга удирдан явуулна.

3. Ёслол үйлдэх газар

3.1 Ёслолыг Богдхан хайрхан уул, Бурхан Халдун уул, Отгонтэнгэр уул, Дарьгангын Дарь овооны тахилгын овооны тус газарт/ эртнээс тахиж ирсэн уламжлалтай тэр / нь үйлдэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

4. Бусад зүйл

4.1 Ёслолын үеийн дэг журмыг тухайн аймгийн Засаг даргын боловсруулсан тусгай хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ. Үүнд ёслолд оролцогсдын байр, орчин, хоол, унаа, зам, тэдгээрийн аюулгүй байдал бүгд багтана. Харин Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд ёслолд оролцох тохиолдолд тэдний аюулгүй байдал ба ёслолын асуудлыг төрийн тусгай хамгаалалтын болон ёслолын алба хариуцан, ёслолын ажиллагааг зохион байгуулах комисстой хамтран гүйцэтгэнэ. Чингэхдээ тухайн ёслолын батлагдсан дэг дарааллыг баримтлана.

4.2 Ёслолын үеэр шашны хувагуудын унших ном, үйлдэх үйлдлүүдийг уул, овоо тус бүрийн тайлгын нь онцлогийг харгалзан үзэж, тухайн аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /түүний тэргүүлэгчид, дарга/ зохицуулна.

4.3 Ёслолын үеэр төрөө дээдлэхийн билэгдлээр төрийн элч төлөөлөгчдийг эрхэмлэн хүндэтгэнэ. Энэ нь шашны эрхэм хувагуудад хамаарна.

4.4 Ёслолын ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өргөн сурталчилна.

4.5 Ёслолын үйл ажиллагааг гэрэл зураг, баримтат кино, цахим хэлбэрээр баримтжуулан Монгол Улсын Үндэсний архивын сан хөмрөгт хадгалуулахыг төр хариуцна.

5. Уул, овооны тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолын үеэр цээрлэх зүйл

5.1 Ёслолын үеэр амьтны амийг тавчиж, цус гаргах, архи уух, маргалдаж сөргөлдөх, цээртэй үг хэлэх, ёс бус авир гаргах болон ёслолын дэг, дарааллыг зөрчихийг цээрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрэм батлах тухай

Монгол Улсын Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн хэлний зөвлөлийн дүрэм"-ийг 1 дүгээр, зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Төрийн хэлний зөвлөлийн шаардагдах зардлыг тухайн жилийн улсын төсөвт тусгаж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

3. Төрийн хэлний зөвлөлийн бүрэлдэхүүнийг "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 138 дугаар

тогтоолын 15 дугаар хавсралт болгон баталсугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт дахь хүснэгтийн 10-ыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.ЭНХБАЯР

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХУХААНЫ
САЙД**

А.ЦАНЖИД

*Засгийн газрын 2004 оны 67 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт*

ТӨРИЙН ХЭЛНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

хэрэгжүүлэхэд энэхүү дүрмийг мөрдлөг болгон ажиллана.

1.1. Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Төрийн хэлний зөвлөл (цаашид "зөвлөл" гэх) нь Төрийн хэлний тухай төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Хоёр. Зөвлөлийн бүрэн эрх

2.1. Зөвлөл нь Төрийн албан ёсны хэлний тухай хуульд заасны дагуу дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Төрийн албан ёсны хэлний тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

2.1.1. орчин цагийн монгол хэлний үгийн сангийн болон хэл зүйн хэм хэмжээ, зөв бичих дүрэм, нэр томъёог шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулан баталгаажуулж хэрэглэх, хэвшүүлэх ажлыг зохион байгуулах;

1.3. Зөвлөл нь боловсрол, соёл, шинжлэх ухаан, хууль зүй, гадаад харилцаа, үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийслэлийн захиргаа болон мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй байна.

2.1.2. ажлын хэсэг, мэргэжлийн комиссыг зохион байгуулж, иргэд, байгууллагын санал, хүсэлтийг судлах, зөвлөмж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөлгөө өгөх;

1.4. Зөвлөл нь Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж төрийн албан ёсны үйл ажиллагаанд дагаж мөрдөх орчин цагийн монгол хэлний хэм хэмжээ, нэр томъёо, зөв бичих дүрмийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох, баталж мөрдүүлэх, хэвшүүлэх, мэргэжлийн зөвлөлгөө өгөх, нэр томъёотой холбогдох асуудлаар дүгнэлт гаргах чиг үүргийг

2.1.3. шинэ болон мөрдөгдөж байгаа нэр томъёо, үг хэллэгийг олон нийтэд мэдээлж, хэвлэн нийтлэх;

2.1.4. орчин цагийн монгол хэлний хэм хэмжээ, нэр томъёо, зөв бичих дүрмийн онол, хэрэглээ, арга зүйн асуудлаар эрдэм шинжилгээний

хурал, зөвлөлгөөн, сургалт, ярилцлага зохион байгуулах;

2.1.5. нэр томъёог зохистой хэрэглэх, хэвшүүлэх сурталчилгаа зохион байгуулах;

2.1.6. шинээр тогтоосон нэр томъёо, зөв бичих дүрэм зэрэг тулгамдсан асуудлаар мэдээлэл, тайлбар, зөвлөмж нийтлэх;

2.1.7. Төрийн албан ёсны хэлний тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

2.1.8. Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн хэрэгжилтийн байдалтай холбоотой ном, хэвлэл, дуут, дүрст, цахим мэдээлэл бүхий мэдээллийн сан байгуулах;

2.1.9. хэвлэл мэдээлэл, радио, телевизийн хэлний соёлд хуулийн дагуу хяналт тавих;

2.1.10. Засгийн газарт жилд нэг удаа ажлаа тайлагнах.

2.2. Зөвлөл нь дараахь эрхийг эдэлнэ:

2.2.1. нэр томъёоны болон хэлний хэм хэмжээ, зөв бичих зүйн салбар зөвлөлийг байгуулан монгол бичгийн хэлний зөв бичих дүрмийг боловсронгуй болгох, шинжлэх ухааны олон салбарын нэр томъёог оноох, жигдлэх ажлыг эрхлүүлэх;

2.2.2. шинээр хэрэглэх, шинэчлэн тогтоох нэр томъёог батлах;

2.2.3. зайлшгүй шаардлагатай мэргэжлийн хүмүүсийг харьяа байгууллагатай нь тохиролцсоны үндсэн дээр ажлын хэсэг болон мэргэжлийн комисст түр хугацаанд гэрээгээр ажиллуулах;

2.2.4. төрийн албан ёсны хэлний хэм хэмжээ, нэр томъёог улс даяар мөрдүүлэх зорилгоор нэр томъёоны толь, ном, гарын авлагыг хэвлүүлж түгээх зэрэг үйл ажиллагаанд шаардагдах зардлыг шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багцад тусган шийдвэрлүүлэх;

2.2.5. мэдээллийн сан байгуулах, судалгаа хийх, дүгнэлт гаргахад хэрэглэгдэх шаардлагатай мэдээллийг холбогдох байгууллагаас гаргуулах;

2.2.6. төрийн албан ёсны хэлний хэм хэмжээ, нэр томъёог дагаж мөрдөх талаар холбогдох байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэр гаргах;

2.2.7. Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн заалтыг зөрчсөн тохиолдолд зөрчлийг арилгах талаар зөвлөмж гаргах, түүнийг эс биелүүлбэл холбогдох саналыг боловсруулан хууль хяналтын байгууллагад хүргүүлэх.

2.3. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, ажлын албатай байна. Ажлын албаны үүргийг Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэн гүйцэтгэнэ.

2.4. Зөвлөлийн дарга нь дараахь бүрэн эрхийг эдэлнэ:

2.4.1. Зөвлөлийн ажлыг удирдах;

2.4.2. Зөвлөлийг төлөөлөх;

2.4.3. Зөвлөлийн ажиллах журам, салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах;

2.4.4. Зөвлөлийн ажлын төлөвлөгөө, гишүүдэд олгох урамшууллыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

2.4.5. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, товыг тогтоох;

2.4.6. Зөвлөлийн хуралдааныг даргалж, хэлэлцсэн асуудлаар гишүүдийн санал тэнцсэн нөхцөлд эцсийн шийдвэр гаргах;

2.4.7. Зөвлөлийн жил бүрийн төсвийн төслийг хянаж батлуулах, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих;

2.4.8. Зөвлөлийн ажлын гүйцэтгэл, төсвийн зарцуулалтыг эрх бүхий байгууллагад тайлагнах;

2.4.9. Төрийн албан ёсны хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангуулах.

2.5. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь дараахь үүргийг гүйцэтгэнэ:

2.5.1. эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хариуцан зохион байгуулах;

2.5.2. Зөвлөлийн ажлын жил, улирлын төлөвлөгөө, зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

2.5.3. Зөвлөлийн даргын зөвшөөрлийн дагуу зөвлөлийн төсвийн зарцуулалтад нэгдүгээр гарын үсэг зурж, хариуцах;

2.5.4. Энэхүү дүрмийн 2.2.3-т заасан хүмүүстэй Зөвлөлийн нэрийн өмнөөс гэрээ байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх;

2.5.5. Зөвлөлийн жилийн ажлын тайланг боловсруулан зөвлөлийн хуралдаанд танилцуулах.

2.6. Зөвлөлийн өдөр тутмын ажлыг ажлын алба гүйцэтгэнэ.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны

зохион байгуулалт

3.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Зөвлөл нь улиралд нэг удаа хуралдах бөгөөд шаардлагатай үед зөвлөлийн дарга, эхсүл гишүүдийн олонхийн саналаар хурлыг зарлан хуралдуулж болно.

3.2. Зөвлөлийн хуралдааны дэгийг зөвлөлийн хурлаар баталж мөрдөнө.

3.3. Хуралдааныг гишүүдийн гуравны хоёр оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцож, хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцож буй гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3.4. Зөвлөл хэлэлцсэн асуудлаараа тогтоол гаргана. Тогтоолд зөвлөлийн дарга гарын үсэг зурна.

3.5. Зөвлөл нь "Төрийн хэлний зөвлөлийн мэдээлэл" цуврал бэлтгэн гаргана.

3.6. Зөвлөл нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

Засгийн газрын 2002 оны 138 дугаар тогтоолын 15 дугаар хэвсрэлт

ТӨРИЙН ХЭЛНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга

-*Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн*

Гишүүд:

-*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал хариуцсан референт;*

-*Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга;*

-*Шинжлэх ухааны академийн нийгмийн ухаан хариуцсан дэд ерөнхийлөгч;*

-*Хуулийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хуулийн бодлогын асуудал хариуцсан газрын дарга;*

-*Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвийн хуулийн нэр томъёоны асуудал хариуцсан албан тушаалтан;*

- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бага, дунд боловсролын асуудал хариуцсан газрын дарга;
- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын асуудал хариуцсан газрын дарга;
- Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын соёлын асуудал хариуцсан газрын дарга;
- Үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны удирдлагын газрын дарга;
- Оюуны өмчийн газрын дарга;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;
- Шинжлэх ухааны академийн нийгмийн ухааны бага чуулганы нарийн бичгийн дарга;
- МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн захирал;
- Монгол Улсын боловсролын их сургуулийн Монгол судлалын сургуулийн захирал;
- Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга;
- Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн шинжлэлийн салбарын эрхлэгч;
- Төрийн хэлний зөвлөлийн ажлын албаны дарга.
- Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал.

Нарийн бичгийн дарга

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Хорио цээрийн дэглэм, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг бууруулах тухай

Дорноговь аймгийн зарим сумын нутагт гарсан малын гоц халдварт шүлхий өвчний голомтыг устгах, халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын үр дүн, мэргэжлийн байгууллагын дүгнэлт, Гамшигтай тэмцэх комиссын хурлын шийдвэрийг харгалзан Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Өргөн, Алтанширээ, Айраг сумдын нутаг дэвсгэрт тогтоосон хорио цээрийн онцгой дэглэм, гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулж 3 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн хорио цээрийн хязгаарлалтын дэглэм тогтоон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. "Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 37

дугаар тогтоолын 2 дугаар зүйлээс "... Сайншанд, ... Эрдэнэ, ... Улаанбадрах, Замын-Үүд ..." гэснийг хассугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2004 оны 37 дугаар тогтоолын 1, 15 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
Н.ЭНХБАЯР
ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД
БӨГӨӨД ХУНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭЧ
Ч.ГАНЗОРИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 3 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 70

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ "Гаалийн газар" гэж нэмсүгэй. нь:

"Конвенци хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2003 оны 145 дугаар тогтоолын хавсралтад "11. Буянт-Ухаа дахь

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД
Н. ЭНХБАЯР
САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД
Ч. УЛААН

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2004 оны 4 дүгээр
сарын 21-ний өдөр

Дугаар 2/01

Улаанбаатар хот

Иргэний хэргийн шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйлийн 4 дэх заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Цэцийн дарга Н.Жанцан даргалж, гишүүн Л.Рэнчин /Илтгэгч/, Н.Чинбат, В.Удвал, Ч.Дашням нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Цэцийн хуралдааны танхимд хийв.

Хуралдаанд өргөдөл гаргагч, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 16 дугаар хороо, 25 дугаар байр, 31 тоотод оршин суух иргэн П.Баттогтох, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, УИХ-ын гишүүн Б.Долгор нар оролцлоо.

Иргэн П.Баттогтох Үндсэн хуулийн цэцэд хандаж 2004 оны 3 дугаар сарын 3-ны өдөр гаргасан өргөдөлдөө Иргэний хэргийг шүүхэд хянан хэлэлцэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйлийн 4 дэх заалтууд нь Үндсэн хуулийн хэд хэдэн зүйл, заалтыг зөрчсөн тухай бичсэнээр үндсэн маргааныг тус дунд суудлын хуралдаанаар авч хэлэлцлээ.

Иргэн П.Баттогтох өргөдөлдөө хоёр үндсэн асуудлыг хөндөж тавьсан байна. Энэ нь:

1. 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж, 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, үйлчилж эхэлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт: *"Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байхад 3 шүүгч гурван өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай хоёр шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хэвсаргана"* гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэжээ.

Тэрээр үүнийгээ дараах үндэслэлээр тайлбарласан байна:

-Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт: **"Бүх шатны шүүх**

хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" гэж заасан байдаг.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйлд шүүгч дангаар хянан шийдвэрлэх хэрэг, эрх зүйн маргааны тухай зохицуулсан байдаг бөгөөд тэдгээрээс бусад хэргийг шүүх, бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэдэг.

Харин уг хуулийн дээр дурдсан 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалтад дүн шинжилгээ хийж үзвэл тухайн хэргийг хянан шийдвэрлэж буй шүүх бүрэлдэхүүнд буй 3 шүүгч 3 өөр санал гаргах боломжийг хуулиар олгосон ба, ингэхдээ шүүх хуралдаан даргалагчийн саналыг нөгөө хоёр шүүгчийн саналаас илүүд авч үзэж 3 өөр санал гарсан бол хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэрэг, маргааныг хамтын зарчмаар шийдвэрлэх тухай заалтын агуулыг зөрчиж байна.

Учир нь тухайн шүүх хуралдаан даргалагч бол уг шүүх хурлыг удирдаж, түүний хэвийн явагдах нөхцлийг бүрдүүлэх үүргийг хүлээсэн байдгаараа л шүүх бүрэлдэхүүнд байгаа нөгөө хоёр шүүгчээсээ ялгаатай бөгөөд бусад байдлаараа тухайн асуудал, хэрэгт нэг л санал өгөх эрхтэй шүүгч юм.

Гэтэл түүний саналыг өөр өөр санал гаргасан нөгөө хоёр шүүгчийн саналаас илүүд үзэж байгаа нь Үндсэн хууль зөрчсөн заалт юм. Үндсэн хуульд заагдсан "хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэх" зарчим бол тухайн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх явдлыг ойлгодог билээ гэжээ.

Өргөдөл гаргагч энэ санаагаа цааш үргэлжлүүлэн тайлбарлахдаа:

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: **"Ардчилсан ёс...нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"** гэж заасан

байдаг бөгөөд "ардчилсан ёс" гэсэн ойлголт нь "аливаа асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх" гэсэн ухагдахууныг өөртөө агуулдаг билээ. Шүүх байгууллага бол төрийг төлөөлж, төрийн нэрийн өмнөөс ард түмэнд үйлчилж байдаг байгууллагуудын нэг тул түүний үйл ажиллагаанд "ардчилсан ёсны зарчим буюу асуудлыг олонхиор шийдвэрлэх" зарчим үйлчлэх ёстой. Энэ нь шүүх хэрэг, маргааныг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх үед тод илрэх учиртай.

Нөгөө талаар 1974 онд Монгол Улс нэгдэн орсон "Иргэний болон улс төрийн эрхийн тухайн олон улсын пакт"-ийн 14 дүгээр зүйлд: "Хүн бүр өөрт нь тулгасан ...иргэний байцаан шийтгэх ажиллагаанд ...шүүхээр хэргээ ...шударгаар шийдвэрлүүлэх эрхтэй" гэж заасан ба тэрхүү шударгаар шийдвэрлүүлэх явдал нь шүүх тухайн хэргийг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэж буй үед шийдвэрийг олонхийн саналаар гаргах байдлаар тодорхойлогдох бөгөөд энэ нь шударга ёсонд нийцэх билээ.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг болон 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн заалт болох Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болгож өгнө үү гэсэн хүсэлт тавьжээ.

2. 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж, 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, үйлчилж эхэлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: "Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, 14 дэх хэсгүүдэд заасан заалтуудыг зөрчиж байна гэжээ.

Өргөдөл гаргагч үүнийгээ дараахь үндэслэлээр тайлбарлаж байна:

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: "Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно" гэсэн заалтад дүн шинжилгээ хийж үзвэл эрх зүйн бүрэн чадамжтай тухайн иргэн шүүхэд өөрийгөө

төлөөлүүлэхдээ зөвхөн хоёрхон арга замыг ашиглах эрхийг нь олгожээ.

Өөрөөр хэлбэл, тухайн иргэн шүүхэд хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх үедээ нэгдүгээрт: өөрийнхөө гэр бүлийн гишүүн төрөл садангаараа, эсвэл хоёрдугаарт: өмгөөлөгчөөр тус тус өөрийгөө төлөөлүүлж эрх, ашгаа хамгаалуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах болж байгаа бөгөөд дээрхи хоёр арга замаас өөр боломжийг иргэнд олгоогүй байна.

Тодруулбал, эрх зүйн бүрэн чадамжтай тухайн иргэн өөрийн гэр бүлийн гишүүн болон төрөл садангийн бус, өмгөөлөгч бус хүнээр өөрийгөө төлөөлүүлэх боломжийг хуулиар олгоогүй байна. Уг төлөөлөх хүн нь тухайн иргэний итгэлийг хүлээсэн бөгөөд эрх, ашгийг хамгаалж чадах хэн ч байж болно.

Жишээ авч үзье: Иргэн Б бусдын компьютерийг түр ашиглаж байх үед цахилгаан тасарч, түүний улмаас тухайн компьютер нь эвдэрсэн байна. Уг компьютерийн өмчлөгч А нь Б-гээс хохирлоо буюу компьютерын үнийг нэхэмжилж шүүхэд хандсан. Иргэн Б өөрийгөө буруугүй гэж үзсэн бөгөөд үндэслэл нь тухайн үед цахилгаан хүчдэл гэнэт ихэсч тасарснаас шалтгаалж, компьютерт нөлөөлсний улмаас уг компьютер эвдэрсэн гэж үзжээ.

Шүүх хурал болох өдөр иргэн Б хөдөө ажлаар явах зайлшгүй шаардлагатай болсон. Энэ тохиолдолд иргэн Б-д өөрийгөө буруугүй гэж батлах ямар боломжууд байна вэ гэвэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу түүнд нэгдүгээрт: өөрийгөө гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, хоёрдугаарт: өмгөөлөгчөөр төлөөлүүлэх гэсэн хоёрхон л боломж байна.

Гэвч түүний гэр бүлийн гишүүн, төрөл саданд өөрийнх нь эрх ашгийг шүүхэд хамгаалчихаар хэмжээний компьютерийн мэдлэгтэй хүн байхгүй, мөн компьютерийн талаар сайн мэдлэгтэй бөгөөд санаанд нь нийцсэн өмгөөлөгч олдохгүй, олдсон ч өмгөөлөгчийн ажлын хөлс нь маш өндөр учир тэрээр төлөх боломжгүй байв.

Одоо түүнд эрх ашгаа хамгаалах бас нэг арга бий. Тэр нь шинжээч томилуулах явдал боловч шинжээч бол түүний эрх, ашгийн төлөө биш, харин хэргийн талаар ач холбогдол бүхий нотлох

баримтыг бий болгох үүднээс тодорхой нэг дүгнэлт гаргадаг билээ. Энэ тохиолдолд иргэн Б өөрөө компьютерийн мэдлэг муутай учир шинжээчийн дүгнэлтийг үнэн зөв эсэхийг үнэлж, дахин шинжээч томилуулах хүсэлт гаргах, эсвэл шүүх хуралдаанд шинжээчийг дуудаж, түүнд мэргэжлийн асуулт тавих зэргээр эрх, ашгаа хамгаалах шаардлага гарч ирж байна.

Харин түүнд компьютерийн программ, техник хангамжийн инженер мэргэжилтэй найз байдаг бөгөөд уг найзаараа шүүхэд өөрийгөө төлөөлүүлэхээр тохиролцож, түүнд итгэмжлэл олгох гэтэл иргэн Б-д хууль зүйн тийм боломж алга байна.

Тодруулбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт түүнд тийм боломж олгоогүй байгаа бөгөөд энэ нь иргэн Б-гийн хууль ёсны эрх, ашгийг шууд зөрчиж байна.

Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсэгт: "...Монгол Улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй" гэж заасан байдаг. Иргэн хүн энэхүү эрхээ эдлэх эсэх нь түүний хүсэл зориг, үзэмжийн асуудал билээ. Хэрэв иргэн энэ эрхээ эдэлж, өөрийнхөө зөрчигдсөн болон зөрчигдөх гэж байгаа эрх ашгаа хамгаалуулахаар өргөдөл, гомдол гаргаж болох ба энэ тохиолдолд хууль зүйн бүхий л бололцоог ашиглах боломжтой байдаг.

Тэрхүү боломжуудын нэг нь бусдаар өөрийгөө төлөөлүүлэх явдал бөгөөд төлөөллийн талаархи үндсэн харилцааг Иргэний хуулийн 62-70 дугаар зүйлүүдээр зохицуулдаг билээ.

Төлөөллийн талаархи уг зохицуулалт нь Иргэний хуулийн 62 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар: "Төлөөлөгчийн бүрэн эрх хуулийн дагуу буюу итгэмжлэлийн үндсэн дээр үүснэ" гэж төлөөллийн харилцаа үүсэх үндэслэлийг заажээ.

Харин уг хуулийн 63 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "Итгэмжлэлээр төлөөлөхөд төлөөлөгч нь иргэний эрх зүйн бүрэн, бүрэн бус, эсхүл хязгаарлагдмал чадамжтай иргэн болон хуулийн этгээд байж болно" гэж заасан бөгөөд уг заалтын агуулгыг үзвэл аливаа хүн төлөөлүүлэгч иргэний эрх зүйн зарим чадамжтай болон иргэний эрх зүйн чадамжгүй иргэнээс бусад хэнээр ч өөрийгөө төлөөлүүлж болохоор байна.

Мөн Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт бичгээр олгосон итгэмжлэлд тавигдах шаардлагыг тодорхойлсон байна.

Ер нь аливаа төлөөллийн харилцаа нь Иргэний хуульд заагдсан дээрхи зохицуулалтын хүрээнд явагдах учиртай. Хэдийгээр салбар эрх зүйн онцлог гэж байх боловч шүүх иргэний хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа л юм бол Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд төлөөллийн харилцааг зохицуулахдаа Иргэний хуульд заасан төлөөллийн талаархи үндсэн зохицуулалтыг хэт явцууруулж тусгах ёсгүй билээ.

Ийнхүү Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсгийг зөрчсөн болон Иргэний хуулийн төлөөллийн талаархи үндсэн зөрчмэг гажуудуулж байна гэжээ. Өргөдөл гаргагч цааш нь тайлбарлахдаа:

-Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт: "...Монгол Улсын иргэн Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...өөрийгөө өмгөөлөх, ...хууль зүйн туслалцаа авах, ...шүүхээр шүүлгэх, ...хэрэгээ шүүх ажиллагаанд биеэр оролцох эрхтэй" гэж заасан.

Энэ эрхүүдийг авч үзвэл:

"...эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шүүхээр шүүлгэх..." эрхүүдийн агуулгад эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзсэн иргэн уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах болон шүүхээр шийдвэрлүүлэхдээ өөрийн эдэлж болох жам ёсны бүхий л эрхүүдийг эдэлж, өөрийнхөө эрх ашгийг хамгаалах явдал багтах учиртай. Иймээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь иргэний гэр бүлийн гишүүн болон төрөл, садангийн бус, түүнчлэн өмгөөлөгч бус хүнээр өөрийгөө төлөөлүүлж шүүхээр эрхээ хамгаалуулах боломжийг явцууруулж, хязгаарлаж байна.

"...өөрийгөө өмгөөлөх..." эрхийн хувьд иргэн өөрийнхөө эрх, ашгийг хамгаалахдаа өмгөөлөгч авч ч болно, авахгүй ч байж болно. Энэ бол түүний үзэмжийн асуудал юм. Иргэний хэргийг шүүхээр шийдвэрлүүлж буй иргэн өмгөөлөгч авахгүй гэж үзэн, өөрийгөө өмгөөлж, өөрийнхөө эрх

ашгийг өөрөө хамгаалж болох бөгөөд энэ эрх нь тухайн хэрэг, маргаанд уг иргэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож чадахгүй болсон тохиолдолд өөрийн гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсвэл өөрийн итгэл хүлээсэн, эрх ашгийг нь хамгаалж чадах хүнээр өөрийгөө төлөөлүүлж, шүүхээр хэрэг, маргаанаа шийдвэрлүүлэх байдлаар илрэх ёстой гэж бодож байна. Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь тухайн иргэнийг өөрийгөө шүүхэд төлөөлүүлэхдээ нэг бол гэр бүлийн болон төрөл садангийн хүнээр төлөөлүүл, эсвэл заавал өмгөөлөгчөөр төлөөлүүл, өмгөөлөгч ав, өөр сонголт, боломж байхгүй гэсэн агуулгатай байгаа бөгөөд энэ нь иргэн хүний "өмгөөлөгч авах эсэх эрх"-ийг өмгөөлөгч зайлшгүй авах үүрэг болгосон шинжтэй заалт болжээ. Иймээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь Үндсэн хуульд заасан "өөрийгөө өмгөөлөх" гэсэн эрхийг зөрчиж байна.

"...хууль зүйн туслалцаа авах..." эрхийн илрэх хэлбэрүүдийн нэг нь иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн иргэн итгэл хүлээсэн, мэргэжлийн хүнээр өөрийгөө төлөөлүүлэх хууль зүйн боломжтой байх явдал юм.

Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь тухайн иргэн мэргэжлийн хүнээс буюу бусдаас /өмгөөлөгчөөс биш/ "хууль зүйн туслалцаа авах эрх"-ийг боогдуулж байгаа нь Үндсэн хууль зөрчиж буй хэрэг мөн.

"...хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох..." эрхийн хувьд авч үзвэл тухайн иргэн шүүх ажиллагаанд биеэрээ оролцох эрх эдлэхийн хувьд тийнхүү оролцох эсэх нь бас л түүний үзэмжийн асуудал билээ. Хэрэв тухайн иргэн иргэний хэргийн шүүх ажиллагаанд биеэрээ оролцох боломжгүй, шаардлагагүй гэж үзвэл оролцохгүй байх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд эрх ашгийг нь хамгаалж чадах хэнээр ч өөрийгөө төлөөлүүлж, шүүх ажиллагаанд оролцуулж болох билээ.

Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь хэрэг, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлж буй тухайн иргэнд хоёрхон сонголт олгосон бөгөөд тэдгээр нь өмнө дурдсанчлан: "гэр

бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсвэл өмгөөлөгчөөр төлөөлүүлэх" байдлаар тусгагдсан нь агуулын хувьд хэрэв тухайн иргэн дээр дурдсан 2 сонголтыг хэрэглэхгүй гэж шийдвэл түүнд шүүх хуралдаанд өөрөө биеэрээ оролцох ёстой болох /нөгөө эрх нь бараг үүрэг болж хувирсан/, эсвэл шүүх ажиллагаанд болон хуралдаанд биеэрээ оролцохгүй гэвэл эрх ашгаа хамгаалж чадахгүй болж, нэхэмжлэл нь шүүхээс буцаагдах нөхцөл байдал бий болж байна.

Иймд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь Үндсэн хуульд заасан "хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох" эрхийг гажуудуулж байгаа нь Үндсэн хууль зөрчиж байна гэжээ.

Өргөдөл гаргагч цааш нь өгүүлэхдээ:

-Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: "**Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна**" гэж заасан байдаг. Энэ заалтын агуулгад иргэний хэргийн шүүх ажиллагаанд тухайн иргэн өөрийгөө иргэний эрх зүйн зарим чадамжтай болон иргэний эрх зүйн чадамжгүй иргэнээс бусад хэнээр ч төлөөлүүлж, эрх ашгаа хамгаалуулж болох тийм хууль зүйн орчин, баталгааг бүрдүүлэх үүрэгтэй байх явдал хамаарагдана. Түүнчлэн "...хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна..." гэсэн заалт нь тухайн иргэн өөрийн хэрэг, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх ажиллагаанд гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн, өмгөөлөгчөөр болон өөрийнхөө эрх ашгийг хамгаалж чадах бусад этгээдээр тус тус өөрийгөө төлөөлүүлж болох боломжийг өөртөө агуулсан маш өргөн хүрээтэй ойлголт билээ.

Гэтэл Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан заалт нь Үндсэн хуулийн дээр дурдсан "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц...хууль зүйн...баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэсэн үүрэг бүхий заалтыг хэрэгжүүлэхэд дөхөм болох биш харин эсрэгээр нь буюу "хүний төлөөлөх, төлөөлүүлэх эрх"-ийг хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэжээ.

Өргөдөл гаргагч ийм үндэслэл, тайлбаруудыг дурдаад хүсэлт болгохдоо:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт, Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг: "Ардчилсан ёс... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэсэн заалтыг тус тус зөрчиж байгаа тул уг заалтыг хүчингүй болгож өгнө үү.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсгийн 1 дэх өгүүлбэр бүхий заалт, Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн холбогдох заалтууд, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг тус тус зөрчиж байгаа тул уг заалтыг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

Өргөдөл гаргагч өөрийн 2004 оны 3 дугаар сарын 3-ны өдөр гаргасан өргөдөлдөө 2004 оны 3 дугаар сарын 15-ны өдөр нэмэлт хүсэлт тайлбар гаргасан байна. Түүнд бичихдээ:

-Зрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн тухай хуульд, мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн давах, хяналтын шатын хурлын хэргийг зохицуулсан заалтуудад хэргийг бүрэлдэхүүнтэй шийдвэрлэж байгаа үед асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ гэж заасан атлаа ганцхан иргэний хэсгийг анхан шатаар 3 шүүхийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэж буй үед 3 өөр санал гарвал даргалагчийн саналаар шийднэ гэж заасан нь энэхүү заалт буруу бөгөөд Үндсэн хууль зөрчиж буйг давхар нотолж байна гэжээ.

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийг мөн зөрчиж байна.

Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: **"Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна"**, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: **"Хүнийг... эрхэлсэн ажил, албан тушаал... аар нь ялгаварлан гадуурхаж үл болно"** гэсэн заалт юм.

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: **"Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно"** гэсэн нь эрх зүйн бүрэн чадамжтай тухайн иргэн шүүхэд өөрийгөө төлөөлүүлэхдээ зөвхөн хоёрхон арга замыг ашиглах эрхийг нь олгосон тухай өмнөх өргөдөлдөө дурдсан билээ.

Харин эрх зүйн бүрэн чадамжтай тухайн иргэн өөрийн гэр бүлийн гишүүн болон төрөл садангийн бус, өмгөөлөгч бус хүнээр өөрийгөө төлөөлүүлэх боломжийг хуулиар олгоогүй байгаа юм.

Харин Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: **"Хуулийн этгээдийг төлөөлж байгаа этгээд өөрийн албан тушаал, эсхүл төлөөлөх эрх олгогдсоныг гэрчилсэн баримт бичгийг шүүхэд үзүүлнэ"** гэж заажээ.

Энэ заалт ёсоор бол хуулийн этгээдийг төлөөлж байгаа этгээд нь тухайн хуулийн этгээдэд ажилладаг албан тушаалтан байж болно, эсвэл уг хуулийн этгээдийг төлөөлөх эрх олж авсан хэн ч байж болохоор байна. Өөрөөр хэлбэл тухайн хуулийн этгээдийн удирдлагаас төлөөлөх эрхийг олж авсан аливаа хүн байж болно.

Гэтэл иргэн өөрийн гэр бүлийн гишүүн болон төрөл садангийн бус, өмгөөлөгч бус хүнээр өөрийгөө төлөөлүүлэх боломжийг хуулиар олгоогүй хэрнээ хуулийн этгээдэд, албан тушаалтанд тийнхүү өөрийн гэр бүлийн гишүүн болон төрөл садангийн бус, өмгөөлөгч бус хүнээр өөрийгөө / хуулийн этгээдийг / төлөөлүүлэх боломжийг олгож байгаа нь иргэнийг албан тушаалтнаас доогуур тавьж, хууль, шүүхийн өмнө ялгаварлан гадуурхаж байна.

-Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: **"Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд... төрийн нэрийн өмнөөс оролцоно"** гэж төрийн байгууллага, албан тушаалтанд өмгөөлөгч бус хүнээр /прокуророор/ эрх ашгаа хамгаалуулж болохоор заасан хэрнээ иргэн хүнд өмгөөлөгч бус хүнээр эрх ашгаа хамгаалуулах боломжийг олгоогүй байгаа нь бас л иргэний албан тушаалтнаас доогуур тавьж, хууль, шүүхийн өмнө ялгаварлан



гадуурхаж байгаа хэрэг билээ гээд, иймд Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн заалтыг зөрчсөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

Энэ өргөдлөөр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэсэн тухай УИХ-д мэдээлж өргөдлийн хувийг хүргүүлснээр УИХ-аас итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр УИХ-ын гишүүн Б.Долгор томилогдож, тэрээр Цэцэд энэ асуудлаар тайлбараа ирүүлсэн байна. Энэ тайлбарт дурдахдаа:

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлд заасанчлан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн өөрийн биеэр буюу төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох, мөн зүйлийн 4 дэх хэсэгт: эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлж болох тухай заажээ. Шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд иргэн, хуулийн этгээдийг төлөөлөх төлөөлөгчийг оролцуулж байгаа институт нь хоёр талтай.

Нэгдүгээрт, иргэн, хуулийн этгээдэд эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь хамгаалахад тусалж байна. Хоёрдугаарт, хэргийн нөхцөл байдлыг зөв тогтоох, түүнийг үнэн зөвөөр шийдвэрлэхэд шүүхэд тус дөхөм болж байгаа билээ. Төлөөлөл нь хуульд зааснаар, эсхүл сайн дураар буюу гэрээгээр төлөөлөх хэлбэртэй байх ерөнхий зарчим энэхүү хуульд тусгагдаж, төлөөлөгчийн бүрэн эрхийг төлөөлөгчөөс олгосон итгэмжлэл, бусад бичиг баримтаар тодорхойлно.

Мөн дээр дурдсан хуульд 18 насанд хүрээгүй этгээд, эсхүл эрх зүйн зарим буюу бүрэн бус чадамжтай, чадамжгүй этгээд төлөөлөгчөөр оролцож болохгүй талаар хуульчилсан юм. Ийнхүү эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөхөд нэгдүгээрт, гэр бүлийн гишүүн, төрлийн эсхүл садангийн хүн нь сайн дураараа оролцоно, хоёрдугаарт Иргэний хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу гэрээний үндсэн дээр төлөөлж болно.

Үүнээс гадна эрх зүйн бүрэн чадамжтай иргэн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо мэргэжлийн үндсэн дээр хамгаалуулах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд Өмгөөллийн тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан өмгөөлөгч-иргэнээр төлөөлүүлнэ.

Түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 23.1-д заасанчлан иргэн өөрийн биеэр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа нь тухайн хэрэгтээ төлөөлөгчийг давхар оролцуулах эрхийг нь хязгаарлаагүй болно. Энэ нь Иргэний хуулиар тогтоосон төлөөллийн ерөнхий зарчим, агуулгад нийцэж байгаа юм. Иймд 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно гэж заасан заалтыг явцуу утгаар нь тайлбарлан ойлгож байгаа нь үндэслэлгүй гэж үзэж байна.

Монгол Улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй гэж заасан Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсгийн заалт нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхийн талаар заасан гэж үзэж байна.

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн Монгол Улсын иргэн хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл, уул, эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...өөрийгөө өмгөөлөх, ...хууль зүйн туслалцаа авах, ...шүүхээр шүүгэх, ...шүүх ажиллагаанд биеэр оролцох эрхтэй тухай заажээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.1-д иргэн өөрийн биеэр буюу төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно гэжээ. Өөрөөр хэлбэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийн оролцогчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ гэсэн үг билээ.

1994 оны 5 дугаар сарын 9-ны өдөр баталсан "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай" хуулийн /одоо хүчингүй болсон/ 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад энэ асуудлыг хуульчлан тогтоож байсан болно.

-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байхад 3 шүүгч гураван өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай 2 шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин

хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

"Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" гэсэн Үндсэн хуулийн энэ заалт нь шүүхээс аливаа хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ бүрэлдэхүүнээр буюу хэд хэдэн шүүгч хамтран хянан хэлэлцэж байх асуудлыг хуульчилсан гэж үзэж байна.

Харин ийнхүү хэрэг, маргааныг хамтран хянан хэлэлцсэн шүүх шийдвэрээ гаргахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114.3-т заасны дагуу олонхийн саналаар шийдвэрээ гаргана. Харин 3 шүүгч гурван өөр саналтай байгаа тохиолдолд гарах нэг гарц болгон шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай 2 шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргахаар 114.4 дэх заалтыг хуульчилсан билээ. Иймд хуулийн дээр дурдсан заалт нь Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна гэжээ.

Өргөдөл гаргагч иргэн П.Баттогтох Цэцийн хуралдаанд оролцож үг хэлэхдээ өргөдөлд бичсэн хүсэлт, тайлбар, үндэслэлүүдээ дэмжиж байгаагаа илэрхийлээд өргөдлийн дагуу асуудлыг шийдэж өгөхийг хүсье гэв.

Хуралдаанд оролцсон УИХ-ын төлөөлөгч Б.Долгор өргөдлийг хүлээж аваад Үндсэн хуулийн цэцэд гаргасан тайлбараа тодруулан дэлгэрүүлж яриу. Ингэхдээ өмнө гаргасан тайлбартаа нэмэлт болгон хэлэхдээ:

-Шүүх хамтын журмаар асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ гэдэг нь хэргийг хэд хэдэн шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэх, хуралд иргэдийн төлөөлөгчдийг оролцуулж хэлэлцэж буй асуудлаар тэдний санал бодлыг авч шийдвэрт тусгах агуулгыг гол нь илэрхийлж байгаа юм. Үүнийг шийдвэр гаргахдаа зөвхөн олонхийн саналаар гаргана гэсэн утгаар тайлбарлах нь өрөөсгөл зүйл болно гэв. Мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4-д өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно гэсэн заалт нь Үндсэн хуульд заасан иргэн хүн хууль зүйн туслалцаа авах эрхийг эдлэхдээ аль болох мэргэшсэн, энэ асуудлыг эрхэлдэг хүнээс авах нь зохимжтой, ингэвэл ажил

хэрэгч, эрхээ хамгаалж буй иргэнд ч илүү тустай, үр дүнтэй гэсэн агуулгаар бичигдсэн зүйл юм. Ингэж хуульд бичигдсэнээр иргэний эрх, эрх чөлөө хязгаарлагдаад, Үндсэн хууль зөрчигдөөд байна гэж үзэх үндэс байхгүй гэв.

Маргагч талуудын тайлбар, үндэслэл, бусад холбогдох баримт бичиг, материалыг хянан үзээд гаргасан дүгнэлтийн **ҮНДЭСЛЭЛ:**

Маргааны I хэсгийн талаар:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт: "бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийднэ" гэж заасан нь 3 буюу түүнээс дээш бүрэлдэхүүнээр асуудлыг шүүх авч хэлэлцэж шийдвэрлэхдээ 1 хүний саналаар биш, оролцсон шүүгчдийн олонхийн саналаар шийдвэр гаргана гэсэн утгыг тодорхой илэрхийлсэн байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: "Ардчилсан ёс ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж заасан нь аль ч төрийн байгууллага асуудлыг хянаж шийдвэрлэхдээ ганцаар захирах, шийдэх ёсыг бус олонхийн саналыг харгалзаж, түүнд үндэслэж асуудлыг шийдэх зарчмыг баримтлах санааг илэрхийлсэн байна. Олонхийн саналаар асуудлыг шийдэх энэ зарчим маргаантай хэрэг, асуудлыг таслан шийдвэрлэдэг хараат бус, шударга шүүхийн үйл ажиллагаанд бүр ч тод томруунаар илэрч байх учиртай.

3. Олонхийн зарчмаар асуудлыг ийнхүү шийдэх энэхүү зарчим Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль зэрэг процессын бүх хуулиудад тодорхой тусгагджээ. Энд хэлэлцэж буй маргааны зүйл болсон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн тухайд гэхэд л энэ зүйлийн 3-т "Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэж байгаа бол олонхийн саналаар шийдвэр гаргана" гэж шууд, тодорхой хэлсэн атлаа мөн тэр дороо энэ зүйлийн 4-т: "Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байхад 3 шүүгч гурван өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргана..." гэж зааж агуулгын илэрхий зөрчил гаргасан байна.

Мөн Шүүхийн тухай Монгол Улсын хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: "Бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэхдээ олонхийн саналаар шийдвэр гаргана" гэсэн нь хууль тогтоогч Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт тодорхойлогдсон "хамтын зарчим" гэсэн ойлголтын гол агуулга нь асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ гэсэн утга гэдгийг салбар хууль гаргахдаа тодруулан зааж өгчээ гэж ойлгогдож байна.

Эдгээрээс үзвэл хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй хэлэлцэх үед 3 өөр санал гарсан бол хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ гэсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх заалт нь Үндсэн хуулийн холбогдох зүйл, хэсгийн агуулга, олонхийн саналаар шийдвэр гаргах зарчмыг зөрчсөн нь харагдаж байна.

Маргааны II хэсгийн талаар:

4. Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: "Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно" гэж Иргэний хэргийн байцаан шийтгэх ажиллагааны төлөөлөлтийн хэлбэрийг тоочиж тодорхойлохдоо төлөөлөлтийн зарим боломж, хэлбэрийг орхигдуулж явцууруулсан тал харагдаж байгаа боловч үүнийг Үндсэн хууль зөрчсөн гэх шууд үндэслэл тогтоогдохгүй байна.

5. Иргэн П.Баттогтох өргөдөлдөө Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйлийн 4 дэх заалтууд нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь заалт, Арван зургадугаар зүйлийн 12, 14 дахь хэсгийн заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчсөн гэж үзэж байгаа нь хүлээж авах боломжгүй байна.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон **ДҮГНЭЛТ ГАРГАХ** нь:

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан "Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэж байхад 3 өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай 2 шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Бүх шатны шүүх, хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4-т "Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 12, 14, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчөөгүй байна.

3. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хонгогт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА
ГИШҮҮД
Н.ЖАНЦАН
Л.РЭНЧИН
Н.ЧИНБАТ
Ч.ДАШНЯМ
В.УДВАЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэлэлцэх хэсэгт хэлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

☎ 329487
Хэлэлцлийн хуудас 2.5